

## **ЭДИЙН ЗАСГИЙН ДИПЛОМАТ АЖИЛЛАГАА: ОНОЛ-ТҮҮХ, ОРЧИН ҮЕИЙН ЗАНГИЛАА АСУУДАЛД**

*Д.Уламбаяр\**

*(Эхлэл нь өмнөх дугаарт)*

### **Эдийн засгийн дипломат ба эдийн засгийн тагнуулын ажиллагаа**

Харьцангуйгаар авч үзвэл төрийн энэ хоёр албаны зорилго нь ямар нэг хэмжээгээр ижилхэн бөгөөд гадаад улс орнуудад тэдгээрийн Засгийн газрын үйл ажиллагааны талаар мэдээ баримт цуглуулж, өөрийн улсын ашиг сонирхлыг хамгаалах зорилготой байдаг. Гэхдээ мэдээ цуглуулах арга барил, үйл явцын хөгжилд энэ хоёр бүтцийн үзүүлэх нөлөө, бие биеэсээ нэн ялгаатай, мэдээ олох эх сурвалж нь ч адилгүй байдаг. Тагнуулын зорилт бол тухайн улсын амьдралын ил ажиглалт хийх боломжгүй, өөрөөр хэлбэл дипломат ажиллагааны нээлттэй бус хүрээг хамрах явдал юм.<sup>18</sup>

Монгол шиг бага, жижиг орны хувьд өндөр технологи, *know how*, үйлдвэрлэлийн схем, сансар, цөмийн болон пуужингийн технологи, нано болон биотехнологи чухал боловч гол нь тагнуулын ажиллагааны гол зорилго нь аюулгүй байдалтай холбоотой нууцын зэрэглэлтэй материалын хадгалалт, хил, гаалийн шалган нэвтрүүлэх ажиллагаа, улс төрчдийн хөрөнгө оруулалттай холбоотойгоор гадаадын компани, ЭСЯ-ныхантай холбогдох авилгал, бохир мөнгө угаалт, хууль бусаар тендерт ялах, Монголыг сонирхогч гадаадын томоохон компаниудын талаарх нууц мэдээ баримтад анхаарлаа хандуулах нь ойлгомжтой. Хилийн чанад дахь ЭСЯ-ны ажлын нэг хэсэг нь гадаад орнуудад нарийн мэргэжлээр суралцаж буй оюутан, эрдмийн зэрэг, цол хамгаалж буй докторант, мэргэжил дээшлүүлэгч, өндөр зэрэглэлтэй үйлдвэрлэлд хууль ёсоор ажиллаж буй өөрийн орны иргэдээс техник, технологийн болон бусад мэдээ цуглуулдаг нь нууц биш юм. Тиймээс эдийн засгийн дипломат ажиллагаанд эдийн засгийн тагнуулын мэдээ чухал нь ойлгомжтой.

### **Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого дахь эдийн засгийн дипломат ажиллагаа: өнгөрсөн ба өдгөө**

1911 оны тусгаар тогтнолын сэргэлтийн дараа Монголын удирдагчид, шинэчлэгчид хоёр хөршөөсөө гадна “гурав дахь” хөрш буюу Өрнөдийн орнуудтай харилцаа тогтоохыг чинхүү эрмэлзэж байсан нь гадаад улс төр, эдийн засгийн бодлогын чухаг чиг шугам байжээ. Энэ нь юуны өмнө Өрнөдийн гурнуудээр тусгаар тогтнолоо хүлээн

\* Д.Уламбаяр - доктор, профессор

зөвшөөрүүлэх, улмаар тэдгээр орнуудтай худалдааны өргөн харилцаа холбоо тогтоох замаар түүнийгээ бататгах үндэсний ашиг сонирхол хийгээд аюулгүй байдалтай ямагт холбогдож байжээ. Үүнд: 1912 оны 11 дүгээр сард Монгол Улсын ГХЯ-наас *Их Фа (Франц), Ин (Англи), Дэ (Герман), Мэй (АНУ), Билиш (Бельги), Бин (Япон), Дан Ма (Дани), Хэ Лан (Голланд), Ау (Австри)* зэрэг есөн гүрэнд илгээсэн ноот бичигт “*дурьдсан улсын Засгийн газруудтай дипломат төлөөлөгчид солилшож, ... харилцан гэрээ байгуулж, худалдаа нэвтрүүлж, улсын найрамдлыг зузаатгаму*”<sup>19</sup> гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

1921 онд үндэсний ардчилсан хувьсгал ялсны дараа 9 дүгээр сарын 14-нд Ардын Засгийн газрын ГХЯ-наас *Монгол Улсыг тусгаар тогтносон тухай гадаад олон улсуудад тунхагласан бичиг* гаргасан нь нэгэн адил Өрнөдийн орнуудад хандсан хэрэг байв. Түүнд: “*...Монголын хүн иргэнийг тус тусдаа энх төвшний улиралд хандуулахыг гүнээ эрмэлзэн бүхий дээр, бас ч гадаад олон улстай гэрээ байгуулан худалдаа арилжааг нэгэн адилаар нэвтрүүлэхийг эрмэлзэн байгаа явдлыг хамтад илэрхийлэн гаргав*”<sup>20</sup> гэж дурьдсан байна. Мөн оны 9 дүгээр сарын 12-нд Ерөнхий сайд бөгөөд ГХ-ийн тэргүүн сайд Д.Бодоо Хаалган хотноо суусан Америк консул Самуэль Сокобиныг хүлээн авч уулзан хэлэлцэхдээ Монголын үндэсний ардчилсан хувьсгал ялсны дүнд Ардын эрхт, хэмжээт цаазат засаг тогтсон үнэнхүү учир байдал хийгээд түүний гадаад, дотоод бодлогын тухай тайлбарлахын хамт өөрийн нэрийн өмнөөс АНУ-ын Гадаад хэргийн Төрийн нарийн бичгийн даргын (тухайн үед Charles Evens Hughes ажиллаж байжээ) нэр дээр илгээх ноотыг ноён консулд гардуулжээ.<sup>21</sup> Тэрхүү ноотод “*...Америк улсын Гадаад хэргийн яамны эрхэм сайд танаа...Одоо гагцхүү тусгаалан илтгэх нь манай Богд хаан ба Засгийн газар хийгээд олны санал улсын Засгийн газраас манай Монголын Ардын Засгийн газартай эртхэнээ гэрээ байгуулан, элчин сайд суулгаж, худалдаа, арилжааг улмаар бадруулан хоёр этгээдийн ашиг тусыг хөгжүүлэхийг хүсч байгаа тул эрхэм сайд Та толилж даруйхнаа баяртай хариу хүртээх ажааму*” гэжээ. Хуучин түүх бичлэгт энэхүү ноотыг Америк руу яаж илгээсэн нь тун бүрхэг байсан юм.

ХБНГУ-ын Холбооны архивийн нэгэн чухал сурвалжид Германы дипломатчдын Монголд хийсэн айлчлалын үеэр *Монгол Улсын Сангийн яамны тэргүүн сайд С.Данзангаас “Их Герман улсаас Думдад Иргэн улсын нийслэлд суугаа Элчин сайдын яамны худалдааны хэргийн зөвлөгч Гипперих”-д* 1922 оны 7 дугаар сарын 18-наар өдөрлөсөн 567 тоот албан захидал илгээжээ. Үүнд: “*...Учир байдал иймийг урьдаар илэрхийлэн гаргаж найртай сайны ёсоор мэдэгдвээс зохихын тулд тусгайлан албаны бичиг шийтгэн гаргаж эрхэм зөвлөгч танд*

*мэдтүгэй хэмээн явуулаад байцаан очиж бидний Монгол Улсын ийнхүү эрхэм их улс лугаа харилцан худалдаа нэвтрүүлж уурд удтал бат зузаан найрамдахыг ихэд эрмэлзэн буй явдлыг уламжлан Засгийн газраа нэвтрүүлж, басхуу олон улсын худалдааны ардад зарлан ухуулах ажаамуу, үүний тулд илгээв”* гээд худалдаа нь зохих хууль журмын дагуу хэрэгжихэд анхаарууштай зарим зөвлөгөөг дурдсан байна.<sup>22</sup> Сайхь нугалбар албан бичгийн (үндсэн эх, орос, герман орчуулгын хамт) гол зорилго нь Монгол Улсын Засгийн газар Герман улсын худалдааны пүүсүүд Монголоос мал болон ангийн гаралтай түүхий эд худалдан авч, Германаас төрөл бүрийн өргөн хэрэглээний бараа авчран худалдаалахад дэмжлэг үзүүлэх төдийгүй цаашид худалдааны харилцаа тогтоох замаар хоёр орны хооронд найрамдалт харилцааг хөгжүүлэх сонирхолтой байгаагаа Бээжин дэх ЭСЯ-аар нь дамжуулан Засгийн газарт нь хүргэх явдал байжээ.

1920-иод онд Монголын нам, засгийн удирдах зарим зүтгэлтнүүд нийгмийн байгуулал, үзэл суртлын ялгааг үл харгалзан өндөр хөгжилтэй Өрнөд Европын зарим орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох чиглэлийг барьж байсныг 1923 оны 7 дугаар сарын 24-нд тусгай комиссоос боловсруулан нийтэлсэн *Эдийн засгийн үндсэн бодлого* хэмээх Засгийн газрын бодлогын шинж чанартай баримт бичиг тодорхой илтгэнэ.

Тухайлбал тэрхүү баримт бичгийн 17 дугаар зүйлд *“Монгол Улсын гадаад харилцааны учир байцаавал Орос, Рибин, Америк, Англи, Герман зэргийн олон их, бага улс дотроос зарим нь хурц эрдэмтэй, зарим нь будуулэг байх мэт чанар дурс адилгүй учраас зүй нь харилцан худалдаа, ашиг, эрдэм, соёлын тухай гэрээ болзоо тогтоон нэвтрүүлэхэд хүрвэл эрх биш хэдэн давхар эргэцүүлэн хянаж тогтоовол зохино. Герман, Англи, Орос, Америк, Хятад, Рибин хэмээн шилэх сонгоход хүрвэл аль ч талаар Герман, Орос, Америк хэмээх мэтээр дэс дараалан орох буй заа”* гэжээ. Энэ баримт бичгийг 1923 оны 7 дугаар сард хуралдсан МАХН-ын II их хурлаас *“намын программд нэмэн өргөтгөж баталсан 9 дүгээр зүйлтэй адил сацуугаар улс төрийн ба намын хэрэгт удирдлага болговол зохино”*<sup>23</sup> гэжээ.

Архивын өөр нэгэн баримт бол 1926 оны 1 дүгээр сард БНМАУ-ын Ерөнхий сайдын жинхэнэ орлогч бөгөөд Аж ахуйн явдлын яамны сайд А.Амар, Бүх цэргийн зөвлөлийн тэргүүлэгч гишүүн бөгөөд Засгийн газрын эрхлэх товчооны гишүүн Н.Жадамбаа нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид ЗХУ-д томилогдон очиж, тус хоёр орны хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тулгамдсан асуудлаар Зөвлөлтийн зохих хүмүүстэй хэлэлцээ хийсэн байна. Төлөөлөгчид ЗХУ-д сар гаруй хугацаагаар байхдаа БНМАУ-ын

Засгийн газрын саналыг албан захидлын хэлбэрээр бичиж, Зөвлөлтийн Дипломат албаны тэргүүн комиссар Г.В.Чичеринд гардуулан өгч зохих хариу авчээ.

Дурьдсан бичигт: "...Үүнд эдийн засгийн тухай хэргийг улс төрийн хэрэгт холбогдуулалгүй хэлэлцэж үл болох тухай явдлыг эрхэм Танаа сануулах юун,.. Ихээхэн чухал болох зүйл нь худалдаа болно.

Монгол Улсын ба мөн улсын худалдааны газрууд болбоос харьяат улсын түүхий эдийг хаана үлэмжхэн их үнэ хургэж болох газраа нэвтрүүлэх ба гадаадаас авч ирэх барааг аль улсад боловсруулсныг хэрэгсэхгүй, гагцхуу чанар сайн, үнэ бага агаад харьяат олон ардын хэрэглэх, дурлах явдалд тавтайяа нийцүүлэхийг нь сонгон бэлтгэн авч ирнэ. Оросын аж ахуйн газруудаас эл манай худалдааны бодлогод саад боогдол учруулж устгахыг хичээх нь олон ардын туйлын ашиг тус ба манай хувьсгалт улсын аливааг үйлдэх боловсруулах хэрэг явдалд их л хор болно.<sup>24</sup> гэсэн байдаг. Эдгээр баримт бол Монголын удирдагчид ЗХУ-аас гадна гурав дахь түнштэй худалдаа, эдийн засгийн хэлхээ, холбоо тогтоох эрмэлзэлтэй байсныг харуулж байгаа юм.

Хэдийгээр ЗХУ болон Коминтерны зүгээс БНМАУ-ын гадаад, дотоод бодлогыг өөрийн чиг шугаманд захируулах арга хэмжээ авсаар байсан боловч Монголын нам, засгийн удирдах зүтгэлтнүүд нийгмийн байгуулал, үзэл суртлын ялгааг үл харгалзан өндөр хөгжилтэй Өрнөд Европын зарим орнуудтай худалдаа, эдийн засаг, соёлын харилцаа тогтоон хөгжүүлэх чиглэлийг барьж байжээ.

Тухайн үеийн Монголын улс төрийн зүтгэлтнүүдийн баримталж байсан дээрх чиг шугам тодорхой амжилтад хүрснийг тэмдэглэх хэрэгтэй.

Ер нь Монгол Улс 1920-иод оны эхнээс Өрнөд Европ, тухайлан Герман (мөн Франц) улстай *ad hoc* харилцаатай байсан гэж үзэж болохоор байна. Улс буюу Засгийн газрын хооронд бие биеэ харилцан хүлээн зөвшөөрөөгүй, үл зөвшөөрөх учир шалтгаантай боловч тодорхой нэгэн асуудлыг шийдвэрлэхийн тулд түр зуур албан ёсны харилцаанд орох тохиолдол олон улсын харилцааны түүхэнд түгээмэл байсан бөгөөд одоо ч байгаа юм. Үүнийг дипломатын болон олон улсын эрх зүйд *ad hoc* хүлээн зөвшөөрөх гэдэг. *Өөрөөр хэлбэл Герман, Франц БНМАУ-ыг ad hoc хүлээн зөвшөөрсөн хэрэг байсан гэж үзэж байна. Ad hoc* хүлээн зөвшөөрснөөр тухайн тохиолдлын хүрээнээс хэтэрсэн эрх зүйн үр дагавар үл гарна.

Монгол Улс 1961 онд НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болсон нь Өрнө дахинтай харилцаагаа тогтоон хөгжүүлэх шинэ боломжийг нээсэн хэдий ч, энэ боломжийг дүүрэн ашиглаагүйгээр зогсохгүй хүйтэн дайны улмаас НҮБ-ын индэр эсрэг тэсрэг хоёр системийн үзэл суртлын тэмцлийн талбар болж, Монгол Улс ч түүнд татагдан оролцож эхэлжээ.

БНМАУ Өрнөдийн орнуудын хоорондын худалдаанд дорвитой өөрчлөлт гараагүй нь Монгол Улс УААА болон хүн амын өргөн хэрэглээний гол чухал бараа бүтээгдэхүүнийг социалист хамтын нөхөрлөлийн орнууд, юуны өмнө ЗХУ-аас худалдан авч байснаар тайлбарлаж болох боловч, нөгөө талд АНУ, ХБНГУ, Англи, Франц, Итали, Австри, Нидерланд, Швейцари, Япон зэрэг орнуудын пүүс нэгдлүүдээс харилцан ашигтай худалдааг хөгжүүлэхээр гаргасан санал санаачилгыг судалж, ажил хэрэг болгохгүй зориуд орхигдуулж, түүнчлэн дээрээс бодлогоор дэмждэггүй байсантай холбоотой. Түүнчлэн Өрнөдийн орнуудтай худалдаа-эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд бидэнд туршлага илт дутагдаж байсан нь нөлөөлсөн ч тодорхой юм. 1990 онд 100 гаруй оронтой дипломат харилцаатай байсан гэхэд дурдсан улсууд БНМАУ-ын гадаад худалдааны нийт эргэлтэд 321,1 сая төгрөг (оны үнээр) буюу дөнгөж 3,3 хувийг эзэлж байжээ.<sup>25</sup>

БНМАУ социалист хамтын нөхөрлөлийн “уялдуулан зохицуулсан гадаад бодлого” гэгчийг хөдөлбөргүй баримталж, тэдгээр орнуудтай “бүх талаар ойртон нягтарч” байв. Өрнөдийн хөгжингүй орнуудтай улс төрийн харилцаа үндсэндээ ёс төдий, эдгээр орноос нэлээдтэй нь хэлэлцээр, протоколын үндсэн дээр соёлын харилцааг хэрэгжүүлж байсан боловч тэр нь далайцаар бага, агуулгаар ядмаг, ихэнхдээ бэлэгдлийн шинжтэй байжээ гэж хэлж болно. Иймэрхүү бодлогын уршгаар Монгол Улс Өрнөдийн орнуудийн дунд “дагуул улс”, “хаалттай орон” хэмээн нэрлэгдэх болсон байна.

Дипломат ажиллагааг улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэх зорилготой илүү холбох, эдийн засгийн дипломат ажиллагааг идэвхжүүлэх талаар 1970-аад оны үеэс ГЯЯ зохих ёсоор анхаарч ажилласан байна. Гадаад худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааг гүйцэтгэх ажлын түвшинд илүү зохицуулалттай болгох явдал чухал зорилт болж байв. Эдгээр салбарыг эрхэлсэн өндөр эрх мэдэлтэй байгууллагууд өөрийн хэрэгт нь бусад байгууллага “хөндлөнгөөс оролцох”-ыг таалахгүй байсан хандлагыг даван туулах шаардлага гарч байжээ. ГЯЯ-ны санаачлагаар Сайд нарын Зөвлөлөөс 1978 онд эдийн засгийн гадаад харилцааны үйл ажиллагаанд дипломат төлөөлөгчийн газруудын гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоол гаргасан нь дээрх зорилгыг хэрэгжүүлэх чиглэлд эрх зүйн үндсийг тавихад чухам алхам болсон ажээ. Энэ тогтоолоор худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны бүх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг дипломат төлөөлөгчийн газрынхаа хэмжээнд удирдаж, биелэлтэд нь хяналт тавьж байх эрхийг түүний тэргүүнд олгож, төрийн актаар бататгасан ажээ.

ДТГ-уудад худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааг эрхлэн явуулах нэгдсэн зааврыг боловсруулж мөрдүүлэхийг ГЯЯ, Гадаад Худалдааны Яам, Гадаадтай Эдийн Засгийн талаар харилцах Улсын Хороо, Шинжлэх Ухаан-Техникийн Улсын Хороонд даалгасан нь бас нэг шинэ зүйл болжээ. Түүнчлэн дээрх салбаруудын ажиллагааны талаар дипломат төлөөлөгчийн газруудын ажлын үр дүнг жил бүр хамтран хэлэлцэж цаашид тавих зорилт, авах арга хэмжээний талаар нэгдсэн удирдамж зөвлөмж өгч байхыг эдгээр байгууллагад үүрэг болгосон ажээ. Гол социалист орнуудад худалдаа, эдийн засгийн харилцаа эрхэлж байсан атташегийн аппаратыг зөвлөхийн товчоо болгон өргөтгөж статусыг нь дээшлүүлэх ажлыг энэ үед дуусгасан байна.

Социалист орнууд биелэх боломжгүй янз бүрийн энх тайванч санал, санаачлагыг үзэл суртал, сурталчилгааны зорилготойгоор дэвшүүлэн тавих дуртай байсны жишээ нь 1981 онд хуралдсан МАХН-ын ХҮШ их хурлаас “Ази-Номхон далайн орнуудын хооронд харилцан үл довтлох, хүч үл хэрэглэх тухай” конвенци байгуулах “энх тайванч” санал дэвшүүлсэн нь амьдралд хэрэгжих улс төр, эдийн засаг, олон улсын харилцааны бодиттой нөхцөл бүрдээгүй байсны улмаас хоосон лоозунгийн шинж чанартай болсон юм. Өөрөөр хэлбэл Монгол Улсын гадаад бодлого үндэсний эрх ашгаас ангид, социалист интернационализмын зарчимд тулгуурласан, хэт улс төржсөн шинж чанартай байв. *Гэвч учир шалтгааны гол нь энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын ангич, үзэл сурталжсан шинж чанар голлож байсан хүйтэн дайны үед холбоотны эрх ашгийг үндэсний эрх ашгаас дээгүүр тавьж байсанд оршино.*

Харин Өрнө, Дорно дахинтай улс төр, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаагаа бүх салбарт иж бүрэн хөгжүүлэх улс төр, эрх зүйн боломж жинхэнэ утгаараа “хүйтэн дайны” төгсгөл үед тохиожээ

1980-аад оны сүүл, 1990-ээд оны заагт Монголын гадаад орчин үндсээрээ өөрчлөгдөж, шинэ орчин, шинэ нөхцөл байдлыг танин мэдэх, түүнд зохицсон шинэ бодлого, шинэ түншлэл бий болгох зорилт тулгаран гарч иржээ. Ханс Моргентаун арга зүйгээр бол юуны өмнө Монгол Улс өөрийгөө үнэн зөв тодорхойлж, нээн харуулах, хоёрт, хэнтэй түншлэх хэмээн бусад улс орнууд, олон улсын байгууллагуудыг сайтар судалж, танин мэдэх, тэгээд хоёр талын бодлого, үйл ажиллагаа хоорондоо хэрхэн нийлж, салж байгааг тодруулах, эцэст нь тэдний стратегийн болон геополитикийн сонирхол, өөрийн үндэсний эрх ашгийн хослол дээр тулгуурласан солиболцлын зөв цэгийг сонгон авч гадаад бодлогын орон зайгаа тэлэх, тусгаар тогтнол, хөгжил дэвшил, бүрэн эрхт байдлаа улс төр, эдийн засаг, дипломатын аргаар хангах явдал юу юунаас чухал болсон байна..

Монгол Улсын гадаад харилцаанд буй болсон шинэ хүчин зүйл нь хоёр хөршөөс гадна АНУ, Япон, Өрнөд Европын зэрэг дэлхийн

бодлогод шийдвэрлэх нөлөөтэй зонхилох орнууд, ОУБ-ууд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болсон явдал мөн. Үүний үндсэн уг сурвалж нь Монголд гарсан ардчилсан өөрчлөлт, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц байсан бөгөөд тэдгээр орнууд ч Монгол Улсыг ардчилсан шинэ тогтолцоонд шилжихэд бүх талын дэмжлэг үзүүлэх, нөгөө талд урд, хойд хоёр хөршид нь шилжилтийг амжилттай даван туулж буйг жишээ болгон харуулах давхар зорилго ч агуулж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Монголд гарсан ардчилсан өөрчлөлт, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц, гадаад бодлогын шинэ чиг шугамыг АНУ, Япон, Европын Холбоо, түүний нөлөө бүхий гишүүн орнууд анхнаас нь дэмжих бодлого баримталсны үр дүнд хоёр талын улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх улс төр, эрх зүйн таатай орчин бүрдсэн хэмээн дүгнэж болох байна. Тийнхүү Монгол Улс, Өрнө, Дорны нөлөө бүхий орнууд болон Европын Холбоотой тогтоосон хоёр талт улс төр, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа улс төр, эрх зүй, худалдаа, хөрөнгө оруулалт, зээл, тусламж, бүс нутгийн хийгээд олон улсын хамтын ажиллагаа, аюулгүй байдал гэсэн чиглэлээр амжилттай хөгжиж ирсэн байна.

Олон улсын харилцааны онолд “*гуравдагч хөрш*”-ийн тухай ойлголтыг тусгайлан тодорхойлсон зүйл одоогоор хараахан гараагүй байна. 1990-ээд оноос Монгол Улсын гадаад бодлогод шинээр буй болсон шинэ чиглэл бол “*гуравдагч хөрш*”-ийн бодлого мөн. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн үсрэнгүй хөгжилтэй холбоотойгоор орон зай, цаг хугацаа, хөршийн тухай уламжлалт ойлголт шинэчлэгдэж байгаатай сайхь бодлого шууд холбогдоно.

2010 оны “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “*Гуравдагч хөрш*”-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ”, харин 2011 оны “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д “*АНУ, Япон, Европын Холбоо... зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх*”-ээр анх удаа бодлогын хэмжээнд тус тус заажээ.

Энэ бодлого Засгийн газрын “*Гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр*”-тэй<sup>26</sup> ч нягт уялдах учиртай. Уг үзэл баримтлалын гол агуулга нь *Монгол Улсын хувь заяа, үндэсний аюулгүй байдал болон хөгжил дэвшлийн асуудал зөвхөн хоёр хөршөөс хамаарч нөхцөлдөж байх бус, мөн дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдийн геополитик, геозэдийн засаг, стратегийн сонирхол, оролцоо, нөлөө хамаарлаас давхар шалтгаалж байх улс төр, эдийн засаг, эрх зүйн орчинг бүрдүүлэхэд оршино*. Үүнд: эдийн засгийн дипломат ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэх ёстой.

“Аливаа улсын гадаад бодлого нь оршин буй газар зүйгээрээ тодорхойлогдоно” гэж Наполеон Бонапарт хэлжээ. Энэ бол жижиг, бага улсад ихээхэн хамаатай үг билээ. Улс гүрэн бүгд нэг нь нөгөөтэйгээ айл хөрш болж зэрэгцэн оршдог. Германы геополитикч, проф. Фридрих Ратцелийн (*Friedrich Ratzel 1844-1904*) “Хөршөө сонгодоггүй” гэж хэлсэн нэгэн үг буй. Энэ бол зөвхөн хил залгасан орны тухайд өгүүлж буй зүйл юм. *Сайн хөршийн харилцааны тухайд бол туунийг заавал айл зэргэлдээ гэхгүй алс холын аль ч оронтой тогтоож болно. Энэ утгаараа хөрш нь хаяа нийлсэн хэдэн ч орон байж болох бөгөөд харин хил залгаагүй хөршөө бол сонгож болно.*

“Гуравдагч хөрш” гэдэг ухагдахуун нь зөвхөн газар зүйн тухай ойлголт бус, тухайлсан нэг улс ч бус, харин улс төр, эдийн засаг, геополитикийн хүрээг хамарсан олон улсын харилцааны онолын цогц ойлголт бөгөөд Монгол Улсын ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоо, нээлттэй, бие даасан гадаад бодлогыг тууштай дэмжигч Өрнө, Дорнын орнуудын бүлэг болон НҮБ зэрэг дэлхийн бодлогод жин нөлөөтэй субъектийг оруулж буй хам ойлголт гэж хэлж болно. Харилцан хамаарал гүнзгийрч, олон улсын харилцааны өөрчлөгдөн буй даяаршсан дэлхий ертөнцөд аливаа бага, жижиг улс орны оршин тогтнох, хөгжил дэвшил, аюулгүй байдал нь гагц цэрэг-стратегийн асуудалтай холбогдохгүй, харин худалдаа, хөрөнгө оруулалт, зээл, тусламж, эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулах, ардчилал, сайн засаглал, хүний эрх зэрэг улс орнуудын хоёр болон олон талт хамтын ажиллагаа, шинжлэх ухаан-технологи, мэдээллийн технологийн үр нөлөөлөл, далайд гарцгүй байршил зэрэгтэй уялдаж өргөн утгыг агуулж байгаа юм. Энэ нь «гуравдагч хөрш»-ийн тухай ухагдахууныг тэлж байгаа хүчин зүйл юм.

Бага, жижиг орнуудын хөгжил, дэвшил, аюулгүй байдлаа хангах гол эх сурвалж нь гадаад харилцаа, идэвхитэй дипломат ажиллагаа мөн. Хоёр их гүрний дунд орших, далайд гарцгүй, зах зээлийн багтаамж бага Монгол Улсын хувьд эдийн засгийн дипломат ажиллагаа хамгийн чухал нь болно. Чингэхдээ: *нэгд*. Гадаад улс төрийн харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны нэгдмэл байдал, цогц шинж, олон тулгуурт, эрх тэгш, харилцан ашигтай, ил тод зарчмыг хадгалах, *хоёрт*. Эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхдээ тухайн улс орны дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг шалгуур болгох, *гуравт*. Гадаад орнуудын Монгол дахь эдийн засгийн бодит ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх бодлого баримтлах эдгээр болно.

*Монгол Улсын эдийн засгийн дипломат ажиллагааны үндсэн зорилго нь гадаад харилцааны арга хэрэгслээр эдийн засгийн өгөөжийг дэмжихэд оршино. Өөрөөр хэлбэл, ДНБ-ий өсөлтөд гадаад бодлого, дипломат ажиллагааны оруулах хувь нэмрийг тууштай нэмэгдүүлж, шууд болон шууд бус үйлчлэлтэй болгох явдал юм.*



Үүнд:

- гадаад худалдааны эргэлтийг өсгөх, ялангуяа *нэмэгдсэн* (нэмүү буюу өндөр өртөг биш) өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлж, экспортын зах зээлийг өргөжүүлэх,

- гадаадын хөрөнгө оруулалтыг, ялангуяа уул уурхай, өндөр технологи, боловсруулах, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарыг бүх талаар дэмжих,

- хөгжлийн зээл, тусламжийг өргөжүүлэх, оновчтой ашиглах, зарцуулалтад хяналт тавих,

- улс орноо болон брэнд бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлд таниулах,

- тэргүүний орнуудын хөгжлийн туршлага, загвар судлах эдгээр болно.

*Дараагийн чухал чиглэл нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад дипломат ажиллагааг чиглүүлэх явдал юм. Хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээр байгуулахад үндэсний эрх ашгийг дээдлэн авилгал, хээл хахуулиас ангид, шинжлэх ухаан, техник-эдийн засгийн үндэслэлтэй судалгаа, мэдээлэлтэй байхыг зүй ёсоор шаардаж байна.* Үүнд: тагнуулын байгууллага чухал үүрэгтэй байх нь мэдээж билээ. Мөн дотоодын хууль, эрхзүйн орчинг ч шинэчлэх учиртай. Нөгөө нэг тал нь эдийн засгийн дипломат ажиллагаа нь өөрөө улс орны аюулгүй байдлыг эдийн засгийн арга хэрэгслээр хангах явдал юм.

Өнөөдрийн Монгол Улсын эдийн засгийн дипломат ажиллагаа нь байгалийн баялаг дээр суурилсан бодлого бөгөөд ОХУ нь өөрийн техник, технологи, хүний нөөцөд тулгуурлаж байгаа бол Монгол Улс гадаадын хөрөнгө оруулалтад суурилж байна гэж үзэж болохоор байгаа юм.

Сүүлийн жилүүдэд төр, засгийн тэргүүн нарын айлчлалын үеэр бизнесийн бүлгийхэн дагалдан явж, худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлаар судалгаа хийх, санал солилцох, хэлэлцээ явуулах барил өргөн дэлгэрч байгаа нь хувийн хэвшлийн гадаад эдийн засгийн хамтын ажиллагааг дипломатын талаар дэмжиж буйн илэрхийлэл юм.

Улс орнуудын төр, засгийн тэргүүн нарын хувийн дотно, найрсаг харилцаа улс төр, эдийн засгийн хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой байдгийг тэмдэглэх хэрэгтэй.

ХБНГУ-ын Шинжлэх ухаан, бодлогын сангийн тэргүүлэх судлаач, доктор К.Мөллер “Герман улс Азид, Монгол Улс Европт” хэмээх өгүүлэлдээ: “Эн тэргүүнд чухалчилж үзсэн түншүүдийн дотор Герман нь нэгдүгээр байрыг хуваалцаж буй Орос, Хятад хоёр ба АНУ, Японы дараа дөрөвт орж байна. Европын бусад орон гэсэн зэрэглэлд мөн л Европын жижгэвтэр, сайхан сэтгэгдэл төрүүлэхүйц орнууд тухайлбал, Дани, Нидерланд, Финлянд, Австри, Швед, Швейцари улс багтаж байгаа бөгөөд тэднийг Энэтхэг, Өмнөд Солонгос, Тайланд, Сингапур,

Туркийн араас байрлуулсан байна. Европын Холбоог яг энэ нэрээр нь нэрлэж оруулаагүй бөгөөд мөн Франц, Их Британи, Итали улсыг ч мөн адил юм. Үүний үндэс шалтгаан нь гадаад худалдааны эргэлтэй холбоотой юм уу, эсвэл гашуун туршлагаас үүдэлтэй эсхийг би мэдэхгүй юм. Харин Брюссель ч, Лондон ч 1990-ээд оны дундаас Монгол дахь үйл ажиллагаагаа идэвхижүүлэхийг оролдож байгаа билээ”<sup>27</sup> гэж Монгол Улсын 1994 оны “Гадаад бодлогын үзэл баримтлал”-ыг шүүмжлэнгүй бичжээ.

Үнэхээр хуучин “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д гол гуравдагч түнш Их Британи, Франц, Итали, Бельги болон Европын Холбоо, Канад улсыг огт дурдалгүй орхигдуулсан юм.

Их Британи улс 1945 оны 2 дугаар сард Холбоотон гурван гүрний Ялтын бага хурлын хэлэлцээрээр АНУ-ын хамт БНМАУ-ын *status-quo*-г хүлээн зөвшөөрч, 1961 онд НҮБ-д гишүүнээр элсэхэд Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүний хувьд “төлөө” саналаа өгч, 1963 онд Өрнөдийн их гүрнүүдээс анх удаа БНМАУ-ыг *de jure* хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтоон, Өрнөдийн их гүрнүүдээс анх удаа 1965 онд Улаанбаатар хотод ЭСЯ-аа нээсэн бол 1973 оны 3 дугаар сард анх удаа Засгийн газрын түвшинд худалдааны хэлэлцээрийг байгуулсан юм. Монгол Улсын цөмийн зэвсгийн бүсийн санаачилгад Их Британи нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүний хувьд бусад гишүүн Франц, АНУ, ОХУ, БНХАУ-тай хамтран баталгаа гаргасан билээ. Их Британи бол Монгол Улсын бэлэн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын Европын Холбоон дахь хамгийн том зах зээл бөгөөд 2009 оны байдлаар тус Холбооны гишүүн орнуудтай хийсэн нийт худалдааны 25 хувь, экспортын 38 хувь нь Их Британид ногдож байна. Монгол Улсаас Их Британид экспортлосон бүтээгдэхүүний 80 хувь нь цэвэршүүлсэн алт, 20 орчим хувь нь самнасан ноолуур болж байна. Британийн хөрөнгө оруулалт Виржини арлуудыг оролцуулаад 140,3 сая ам.доллар, бүртгэгдсэн компанийн тоо 103 хүрч Монголд оруулсан хөрөнгө оруулалтын жагсаалтын 5-8 дугаарт орж, Европын Холбооны зөвхөн ТАСИС хөтөлбөрийн шугамаар Монгол Улсад үзүүлсэн тусламжийн 16 орчим хувийг Британийн тусламж эзэлж байв.

2009 оны 10 дугаар сард “Оюу толгойн” төслийн хөрөнгө оруулалтын гэрээнд холбогдох талууд гарын үсэг зурсан нь дэлхийд нэр хүндтэй, Лондонд бүртгэлтэй Английн “Rio Tinto” үндэстэн дамнасан группын томоохон шууд хөрөнгө оруулалт орж ирэх боломжтой болов. Төсөл амжилттай хэрэгжсэнээр урьдчилсан байдлаар Монгол Улсын ДНБ ойролцоогоор 5 дахин өсч, ядуурлыг бууруулах, ажлын байрыг шинээр буй болгох, нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал түлхэц болох юм.

Франц нь 1920-иод онд Монголтой соёл, боловсролын талаар нягт харилцаатай байсан Өрнөдийн орнуудын нэг бөгөөд БНМАУ-аас НҮБ-д гишүүнээр элсэхийг хүсч 8 удаа өргөдөл гаргасан 1946-1961 оны хоорондох 15 жилийн туршид НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн Франц улс л элдэв тайлбар, шалтаг, шалтгаан, ил далд эрх ашиг, болзол тоочилгүй, бусад гүрний нөлөөнд авталгүй, бие дааж “төлөө” саналаа өгч, 1965 онд БНМАУ-ыг *de jure* хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтоон, 1966 онд Их Британий дараа Улаанбаатарт ЭСЯ-аа нээсэн улс билээ.

Ураны хайгуул, олборлолт, цөмийн эрчим хүчний салбарт хамтран ажиллах Европын Холбооны гол түнш бол найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээтэй Франц улс мөн.

Монгол Улс Европын Холбооны хооронд харилцаа, хамтын ажиллагаагаа нэгэнт буй болсон улс төр, эрх зүйн үндсэн дээр бодитойгоор хөгжүүлэх эрх ашгийг удирдлага болгон Бельгийн Вант улс болон Европын Холбооны дэргэд (Брюссельд) байнгын ЭСЯ-аа нээн ажиллуулахаар Монгол Улсын Засгийн газар 1992 оны 3 дугаар сард шийдвэрлэж, мөн оны 6 дугаар сард ЭСЯ-аа албан ёсоор нээжээ. Бельги нь Герман, Францын дараа гуравт орох импортын түнш юм. Их наймын гишүүн Итали улс Өрнөд Европ дахь Монгол Улсын худалдааны гол түншүүдийн нэг мөн. Үүнтэй нэгэн адил Канад улсыг ч тэмдэглэх хэрэгтэй.

### **Эдийн засгийн дипломат ба Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал**

Эдийн засгийн гадаад харилцаа улс гүрнүүд, ялангуяа бага, буурай улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолтой амин чухал холбоотой. Учир түүний үр шимийг дээд зэргээр ашиглахыг эрмэлзэхийн зэрэгцээгээр болзошгүй сөрөг нөлөөллийг бүх аргаар хязгаарлахад онцлон анхаарах ёстой. Шинэчилсэн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тус орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан доор дурдсан зарим зүйлүүдийг онцлон заасан байна. Үүнд:

- Эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхийг бүрдүүлэх, тодорхой салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай олон тулгуурт эдийн засгийн бүтцийг буй болгох,
- Үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь, оролцоог нэмэгдүүлэх, хамгаалах бодлого хэрэгжүүлж, бизнесээ өргөжүүлэх, олон улсын тавцанд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх,
- Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрүүлэхгүй байлгах бодлого баримтлах, Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж,

стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтлах,

- Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхдээ үндэсний аюулгүй байдлын баталгааг хангахыг чухалчилж, түүхий эдийн хавсарга, гадаад, дотоодын улс төр, бизнесийн ашиг сонирхлын сэргөлдөөний талбар болох, байгаль орчныг доройтуулахаас сэргийлэх, уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлж, орлогод тавих хяналтыг сайжруулах болон бусад олон чухал асуудлыг тус тус цохон заажээ.<sup>28</sup>

Гадаад бодлогын үзэл баримтлалд: үндэсний ашиг сонирхлыг ямагт дээдлэхийн хамт бусад улсын хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэхийг нотлоод гадаад орнуудтай харилцан ажиллахдаа эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх байдалд орохоос сэргийлэх, олон улсын аж ахуйн харилцааны хэм хэмжээг баримтлан эрх тэгш, харилцан ашигтай байх, хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх бодлого явуулна гэж заасан байна.<sup>29</sup> Эдгээр нь Монгол Улсын эдийн засгийн дипломат ажиллагааны чухал хэсэг мөн.

### **Монгол Улсын эдийн засгийн дипломат ажиллагааны үр дүн**

Бид өнгөрсөн түүхийн алдаа, сургамж, тулгамдаж буй бэрхшээл, сорилтыг ярих нь зүйн хэрэг, түүнчлэн олсон ололт амжилтаараа бахархах нь дараа дараачийн зорилтуудыг шийдвэрлэх эрч хүч, урам зориг өрнүүлдэг нь үнэн билээ.

Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойшхи хорин жилд хамгийн том амжилт гаргасан салбар бол гадаад харилцааны салбар даруй мөн. Үүнийг тоон үзүүлэлтээр хэмжих боломжгүй юм. Голлох үр дүнгээс дурьдвал:

1989 оны 8 дугаар сард ЕЭЗХН буюу Европын Холбоотой дипломат харилцаа тогтоож, 1992 оны 6 дугаар сард “Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр” байгуулав.

1990 оны 3 дугаар сард БНСУ-тай дипломат харилцаа тогтоов.

1990 оноос НҮБ-тай хамтын ажиллагаагаа жинхэнэ ёсоор хэрэгжүүлж эхлэв.

1991 оны 2 дугаар сард ОУВС, Дэлхийн банк, АХБ-д гишүүнээр элсэв.

1991 оны 9 дүгээр сард Монголд хандивлагчдын бүлэг албан ёсоор байгуулагдаж, 2003 он хүртэл 1,3 тэрбумын буцалтгүй тусламж, 1,1 тэрбум ам.долларын хөнгөлттэй зээл авч ашиглажээ.

1997 онд ДХБ-д элсэв.

**Монгол Улс хэрэг дээрээ “гуравдагч хөрш”-тэй болж, түүний эрх зүйн үндсийг бүрдүүлэв.**

Монгол Улс 1997 онд Японтой “Иж бүрэн туншлэл”, 2011 онд “Стратегийн туншлэл” тогтоох, 1999 онд Турктай “Иж бүрэн туншлэл”, 1999 онд БНСУ-тай “Харилцан нөхсөн хамтын ажиллагаа, хөгжлийн туншлэл”, 2006 онд “Сайн хөршийн найрамдал, хамтын ажиллагааны туншлэл”, 2003 онд ОХУ-тай “Сайн хөршийн уламжлалт туншлэл”, 2006 онд “Стратегийн туншлэл”, 2003 онд БНХАУ-тай “Сайн хөршийн харилцан итгэсэн туншлэл”, 2011 онд “Стратегийн туншлэл” тогтоохоор урьдчилан тохиролцов. 2004 онд Канадтай “Өргөн хүрээтэй туншлэл”, 2004, 2005 онд АНУ-тай “Стратегийн туншлэл”, 2007 онд Казахстантай “Өргөн хүрээтэй туншлэл”, 2008 онд ХБНГУ-тай “Иж бүрэн туншлэл”, 2009 онд Энэтхэгтэй “Иж бүрэн туншлэл”-ийн харилцааны эрх зүйн баримт бичгүүдийг тус тус байгуулсан бөгөөд Европын Холбоотой “Туншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн цуврал яриа хэлэлцээ 2009 оны 9 дүгээр сард эхлээд 2010 оны 12 дугаар сард хэлэлцээрийг үзэглэж, амжилттай өндөрлөв. 1995 онд Өрнөд Европын орнуудаас анх удаа Европын Холбооны жинтэй, нөлөө бүхий гишүүн ХБНГУ-тай “Монгол Улс, ХБНГУ-ын харилцааны үндсийн тухай Тунхаглал”, 1996 онд Францтай “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг анх удаа байгуулсан нь ч дипломат ажиллагааны чухал амжилт мөн.

1997 оны 11 дүгээр сард Европын хөрөнгө оруулалтын банкттай “Туншлэлийн ерөнхий хэлэлцээр”, 2000 оны 5 дугаар сард ЕСБХБ-ны гишүүн анхны Дорно дахины орон болов.

2003 оны 12 дугаар сард хуучнаар ЗХУ-ын үед үүсч буй болон хуримтлагдсан улс төр, үзэл суртлын шинжтэй их өрийг тэглэж, 2010 оны 12 дугаар сард үлдсэн үлдэгдэл өрийн хэсгийг эцэслэн шийдвэрлэв.

2005 оны 7 дугаар сараас Европын Холбооны “Сайн засаглал, тогтвортой хөгжил” болзлын нэмэлт ХЕС-д 2011 он хүртэл хамрагдаж, Монголын 7200 нэр төрлийн бүтээгдэхүүн ЕХ-ны гишүүн 27 орны зах зээлд тарифгүй нэвтрэх болсон нь Монголын экспорт, хөрөнгө оруулалтыг дэмжих, ажлын байр шинээр буй болгох, эдийн засгийн өсөлтийг хурдасгахад чухал ач холбогдолтой болов. Европ тив бол Монгол Улсын хагас болон бүтэн боловсруулсан бүтээгдэхүүний экспортын томоохон зах зээл мөн. Европ руу чиглэсэн экспорт ийнхүү өсч байгаа нь Европын Холбооны Нэмэлт Хөнгөлтийн Ерөнхий Системийн чухал үр дүн мөн. Харин цаашид 2015 он хүртэл хамрагдах чиглэлээр ажиллах шаардлагатай байна.

2005 оноос ДХБ-ын Оёмол, сүлжмэл бүх төрлийн бүтээгдэхүүний талаарх олон талт хэлэлцээр чөлөөлөгдөж, Монгол Улс Өрнөдийн зах зээлд Хятад, Энэтхэг зэрэг оронтой ижил түвшинд өрсөлдөх болсон нөхцөлд Европын Холбооны Нэмэлт ХЕС-д хамрагдсан нь бүр ч ач холбогдолтой болсон байна.

АНУ-ын Мянганы хөгжлийн сангаас 285 сая ам.долларын буцалтгүй тусламж авах асуудал шийдэгдэв.

АНУ, БНСУ, Бельгийн Вант улс болон ЕХ-ны дэргэд, БНТуркУ, Тайландын Вант улс, Казахстан, Сингапур, Канад, Австри, Австрали, Кувейт, Швед зэрэг улсуудад Монгол Улсын ЭСЯ-ыг (2011 онд Италид ЭСЯ шинээр нээх талаар ГХЯ ажиллаж байгаа ажээ) шинээр эмхлэн байгуулж, түүнд худалдаа-эдийн засгийн зөвлөх, атташегийн орон тоог буй болгосон нь эдийн засгийн эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьсан хэрэг мөн. Канад нь Монгол Улсад ЭСЯ-аа нээсэн нь эдийн засгийн эрх ашигтай шууд холбоотой байв. Учир нь сайхь улсын хөрөнгө оруулалт, ялангуяа уул, уурхайн салбарт эрс нэмэгдэж, худалдаа өргөжин, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болсон явдал юм.

1990-ээд оноос гадаад бодлогод гарсан шинэ зүйл бол Өргөмжит консулын институт буй болж, 30 оронд 60 гаруй Өргөмжит консул Монгол Улсын эрх ашгийг хилийн чанадад төлөөлөх болсон нь “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд явуулж буй эдийн засгийн дипломат ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг юм.

Монгол Улс гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих бодлого явуулсны үр дүнд уул, уурхай, ашигт малтмалын салбарт хоёр хөрш болон “гуравдагч хөрш” орнуудын геополитик, эдийн засгийн бодит сонирхол хэрэг дээрээ буй болов.

Стратегийн “Оюу толгойн” зэс, алтны ордод Канадын “Ivanhoe minings”, Английн “Rio Tinto” корпораци хөрөнгө оруулалт хийхээр гэрээнд гарын үсэг зурж, гэрээ 2010 оны 4 дүгээр сараас хүчин төгөлдөр болов. “Оюу толгой” төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын ДНБ ойролцоогоор 40 их наяд төгрөгт хүрнэ хэмээн урдчилсан тооцоог Сангийн яам гаргасан байна. 2010 оны байдлаар Монгол Улсын ДНБ 7,8 их наяд төгрөг байв.

Ураны хайгуул, олборлолт, цөмийн эрчим хүчний салбарт хамтран ажиллах Европын Холбооны гол түнш бол найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээтэй Франц улс мөн. Мэргэжилтнүүдийн урьдчилсан тооцоогоор Монгол Улс 1,6 сая тонн ураны нөөцтэй, үүгээрээ дэлхийн эхний 10-т орж байгаа ажээ. Францын “Areva” компани Дорноговь аймагт 1996 оноос хайгуулын үйл ажиллагаа явуулж, одоо олборлолт эхлэхэд бэлэн болсон байна. 2009 оны 3 дугаар сард Ерөнхий сайдын С.Баярын Францад хийсэн албан ёсны айлчлалын үеэр “Areva” группын Ерөнхийлөгч, хатагтай Анн Лувержан хамтын ажиллагааны өнгөрсөн хугацааны ололт, амжилт, туршлагадаа сэтгэл хангалуун байгаагаа онцлоод ураны салбарт Монгол Улстай хамтарсан үйлдвэр байгуулах саналаа илэрхийлжээ.

Тус группын ерөнхийлөгч, хатагтай Анн Лувержан мөн оны 10 дугаар сард Монголд айлчилж, Цөмийн энергийн газартай “Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор

ашиглах салбар дахь хамтын ажиллагааны тухай харилцан ойлголцлын Санамж бичиг”-т гарын үсэг зурсан нь ойрын таван жилд энэ чиглэлд Монгол Улсад 500 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийх боломж олгож байгаа ажээ. Цаашлаад Монгол Улсад ойрын ирээдүйд бага оврын атомын цахилгаан станц барьж байгуулах асуудал яригдах болов. Түүнчлэн цөмийн эрчим хүчний найдвартай аюулгүй байдлын асуудал хурцаар тавигдаж байгааг анхаарах ёстой болж байна.

БНХАУ-ын Газрын тосны улсын корпорацийн дэд компани “Петро Чайна Дачин” ХХК хайгуулын үйл ажиллагаагаа дуусгавар болгосноор Тамсагийн сав газарт 119,02 сая тонн түүхий тосны нөөцтэй нь тогтоогдов. Одоогийн байдлаар Монголын газрын хэвлийд 1,6 тэрбум тонн тос байгаа нь илэрч Монгол Улс анх удаа дэлхий дахинд газрын тос олборлогч орон боллоо гэдгээ 2010 оны 2 дугаар сард зарлан тунхаглав. Энэ нь дэлхийд газрын тос олборлогч 100 гаруй орон байдгаас илрээд байгаа нөөцөөрөө 33 дугаар байрт орж байна.

“Таван толгойн” коксжих нүүрсний ордод Япон, БНСУ хамтран ажиллах саналаа илэрхийлж эхлэв.

2006 онд болсон Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Гаваны дээд хэмжээний уулзалт дээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Олон улсын судалгааны Төвийг Улаанбаатарт байгуулахаар болж, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мунь Монгол Улсад 2009 оны 7 дугаар сард хийсэн айлчлалынхаа хүрээнд Төвийг албан ёсоор нээсэн юм. Төвийг Улаанбаатарт байгуулсан нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд тус дөхөм үзүүлэх төдийгүй Монгол Улсад байгуулагдаж буй НҮБ-ын статустай анхны олон улсын байгуулага болох учраас улс төрийн ч чухал ач холбогдолтой хэмээн үзэж болно.

### **Монгол Улсын эдийн засгийн дипломат ажиллагааны ойрын ирээдүйн боломж хийгээд сорилт**

Монгол Улсын хоёр болон олон талт хамтын ажиллагааны улс төр, эрх зүйн орчин үндсэндээ бүрэлдсэн гэж үзэж болно.

Дэлхийн худалдаа-эдийн засаг, валют-санхүүгийн тогтвортой байдал Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлнө. Ойрын ирээдүйн томоохон сорилт нь Дэлхий түүхий эдийн зах зээл дээрх Монгол Улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн зэс, алт, ноолуурын, импортын шатахууны үнийн өөрчлөлт, валютын ханшны хэлбэлзэл, цаг уурын өөрчлөлт, байгалийн гамшиг, уламжлалт бус шинэ өвчний цар тахал зэрэг болно. Тиймээс урдчилан сэргийлэх дипломат ажиллагаа, хямралын менежмент нэн чухал байгаа болно.

“Гуравдагч хөрш”-ийн өндөр технологид суурилсан дэлхийд тэргүүлэгч хөрөнгө оруулалтыг татах үндсэн дээр стратегийн орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, эцсийн бүтээгдэхүүн

үйлдвэрлэх тухайлан, газрын тос боловсруулах болон зэс хайлуулах үйлдвэр, бага оврын атомын цахилгаан станц барьж байгуулах, био болон нано технологид тулгуурласан эрчимжсэн ХАА-г буй болгох, экспортын зах зээлийг өргөжүүлэх нь эдийн засгийн дипломат ажиллагааны чухал чиглэл мөн.

Мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Монгол Улс АПЕК-т элсэхийг эрмэлзэнэ гэж тусгасан. 1994 оны Индонезийн Богорын дээд хэмжээний уулзалтаас АПЕК-ын хөгжиж буй гишүүн эдийн засаг 2020 он гэхэд худалдаа, хөрөнгө оруулалтыг бүрэн чөлөөлөх тухай заасан билээ. Хэрэв Монгол Улс АПЕК-г элссэн тохиолдолд 2020 онд хүссэн, эс хүссэн худалдаа, хөрөнгө оруулалтыг чөлөөлнө. Энэ тохиолдолд үндэсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадавхи, эдийн засгийн аюулгүй байдлыг хэрхэн, яаж хангах асуудал цоо шинээр гарч ирэх нь дамжиггүй. Энэ бол томоохон сорилт мөн. Мехик 1988 онд АНУ, Канадын хооронд байгуулагдсан Умард Америкийн Чөлөөт худалдааны бүсийн хэлэлцээрт (NAFTA) 1992 онд нэгдэн орсны дараа тус улсын эдийн засаг-санхүү гүн гүнзгий хямралд орж байсныг анхаарах хэрэгтэй болов уу.

Эцэст нь, эдийн засгийн дипломат ажиллагаа нь Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулах, Мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх чухал хүчин зүйл мөн.

### ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

18. Попов В.И.
19. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. I боть, УБ., 1964
20. мөн тэнд
21. Campi A.J. "Perceptions of the Outer Mongols by the US Government as a reflected in Kalgan (Inner Mongolia) US consular records 1920-1927" Mongolian Studies. Vol. XIV, year 1992, p. 115
22. Bundesarchiv. (Barch, R-9208/2358)
23. Эдийн засгийн үндсэн бодлого. Нийслэл Хүрээ., Зургаан сарын арван нэгэн, Олноо өргөгдсөний арван гуравдугаар он, Европын долоон сарын хорин дөрвөн, УТТА. Лавлах номын сан 3/2330-ын 7-8 дахь тал, хуулга
24. УТТА. Ф.172.Т.5.ХН.98
25. БНМАУ-ын УААА-70 жилд (1921-1991 он). УБ., 1991
26. Гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр. УБ., 2009
27. "Монгол-Германы харилцаа: өнгөрсөн үе-эдүгээ-хэтийн төлөв", Монгол Улс, ХБНГУ-ын хооронд дипломат харилцаа тогтсоны 30 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын материал, УБ., 2004, 15-23 дахь тал
28. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010
29. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. УБ., 2011